



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/007/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитор: Ч.Мөнхбулган
Утас: 261883 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn
Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг
Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/713
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санд төвлөрүүлэх орлогын бүртгэл, хяналт, холбогдох асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцох асуудал хангалтгүй, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зэрэг 109,851.2 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон 80,524.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сангийн дансанд тусгай хамгаалалттай газар нутаг аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж болон ажил, үйлчилгээний нэг удаагийн хөлс 249,965.7 мянган төгрөг, байгаль орчин болон байгалийн

нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөр 3,845,541.3 мянган төгрөг, тусгай зориулалтаар агнах, барих амьтны дуудлага худалдааны орлого 2,416,166.0 мянган төгрөг, ойн дагалт баялгийн дуудлага худалдааны орлого 4,426,813.7 мянган төгрөг, нийт 10,938,486.7 мянган төгрөг төвлөрснөөс 10,872,231.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Байгаль орчин уур амьсгалын санг ажлын албагүй байхаар хуульчилсан боловч Засгийн газрын 2012 оны “Зохион байгуулалт, орон тооны хязгаар батлах тухай” 189 дүгээр тогтоолын дагуу сангийн ажлын алба 5 орон тоотойгоор ажиллаж байна.

Бусад асуудал

Байгаль орчин уур амьсгалын сан нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн цаглабарт хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт материалыг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	193,093,188.00	5,910,742.28
35	БАРАА МАТЕРИАЛ	193,093,188.00	5,910,742.28
354	Хангамжийн материал	193,093,188.00	5,910,742.28
35410	Бичиг хэргийн материал	1,327,600.00	314,000.00
35420	Аж ахуйн материал	1,046,300.00	996,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,154,000.00	4,330,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,500.00	33,272.77
35470	Бусад хангамжийн материал	186,559,788.00	237,169.51
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	58,772,627.21	41,778,529.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	58,772,627.21	41,778,529.36
392	Биет хөрөнгө	58,669,960.65	41,719,862.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	11,409,752.91	11,409,752.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,409,752.91)	(11,409,752.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,273,879.00	59,443,879.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,892,296.18)	(24,436,832.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,531,456.00	27,531,456.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,243,078.17)	(20,818,639.41)
393	Биет бус хөрөнгө	102,666.56	58,666.52
39301	Программ хангамж	1,120,000.00	1,120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,017,333.44)	(1,061,333.48)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	251,865,815.21	47,689,271.64
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,217,900.00	9,302,842.33
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,217,900.00	9,302,842.33
413	Өглөг	9,217,900.00	9,302,842.33
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	84,942.33
4136	Бусад өглөг	9,217,900.00	9,217,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9,217,900.00	9,217,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	242,647,915.21	38,386,429.31
51	Засгийн газрын хувь оролцоо	242,647,915.21	38,386,429.31
512	Хуримтлагдсан үр дүн	242,647,915.21	38,386,429.31
51210	Өмнөх үеийн үр дүн	242,647,915.21	242,647,915.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	(204,261,485.90)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	251,865,815.21	47,689,271.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,238,731,939.27	11,571,077,781.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,657,564,020.16	4,095,506,990.58
120	Нийтлэг татварын бус орлого	3,657,564,020.16	4,095,506,990.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,657,564,020.16	4,095,506,990.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,471,564.61	184,217,810.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,408,769,835.55	3,911,289,180.08
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	186,322,620.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,581,167,919.11	7,475,570,791.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	641,726,800.00	632,591,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	641,726,800.00	632,591,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,939,441,119.11	6,842,979,691.05
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,874,445,733.11	5,736,638,523.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	64,995,386.00	1,106,341,168.05
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,015,934,835.50	11,703,714,664.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,015,934,835.50	11,703,714,664.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,174,249.27	830,511,041.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,248,548.75	164,337,978.37
210101	Үндсэн цалин	68,246,839.28	102,174,130.23
210102	Нэмэгдэл	29,605,319.47	27,658,486.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,779,790.00	22,980,000.00
210104	Урамшуулал	8,616,600.00	11,525,362.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,438,032.86	20,881,100.00
210201	Тэтгэврийн даатгал	13,583,703.32	14,331,217.05
210202	Тэтгэмжийн даатгал	2,429,118.40	1,637,470.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	808,141.07	818,735.39
210204	Ажилгүйдлийн даатгал	249,099.50	818,735.39
210205	Эрүүл мэндийн даатгал	2,367,970.57	3,274,941.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,563,825.96	6,890,490.26
210301	Гэрэл, цахилгаан	1,040,000.00	1,610,000.00
210302	Түлш, халаалт	2,658,535.28	3,613,428.76
210303	Цэвэр, бохир ус	865,290.68	1,667,061.50
2104	Хангамж, бараа материалын зардал	13,889,691.47	131,074,103.93
210401	Бичиг хэрэг	4,906,825.00	3,753,600.00
210402	Тээвэр, шатахуун	6,379,095.00	4,562,477.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,385,122.47	2,045,177.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,218,649.00	-
210408	Бараа материал акалсны зардал	-	120,712,848.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,194,000.00	2,601,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,752,000.00	2,601,400.00
210604	Урсгал засвар	6,442,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,264,000.00	1,920,371.00
210702	Дотоод албан томилолт	1,264,000.00	1,920,371.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	454,847,910.00	475,934,213.71

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,393,390.00	470,934,213.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	347,600.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,728,240.23	26,871,384.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,992,264.00	6,189,620.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,620,000.00	6,432,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,115,976.23	14,249,264.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,854,131.00	972,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,854,131.00	972,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,854,131.00	972,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,333,906,455.23	10,872,231,622.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,333,906,455.23	10,872,231,622.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	222,797,103.77	(132,636,882.68)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,280,124.99	68,354,603.22
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,280,124.99	68,354,603.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,280,124.99)	(68,354,603.22)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	221,516,978.78	(200,991,485.90)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,054,982,346.27	11,571,077,781.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,471,241,400.16	4,095,506,990.58
120	Нийтлэг татварын бус орлого	3,471,241,400.16	4,095,506,990.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,471,241,400.16	4,095,506,990.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,471,564.61	184,217,810.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,408,769,835.55	3,911,289,180.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	641,726,800.00	632,591,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	641,726,800.00	632,591,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	641,726,800.00	632,591,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,942,014,146.11	6,842,979,691.05
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,877,018,760.11	5,736,638,523.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	64,995,386.00	1,106,341,168.05
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	7,023,894,746.27	11,571,077,781.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,023,894,746.27	11,571,077,781.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	653,134,160.04	697,874,159.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,248,548.75	164,253,036.04
210101	Үндсэн цалин	63,097,468.32	100,258,075.55
210102	Нэмэгдэл	34,754,690.43	29,474,267.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,779,790.00	22,980,000.00
210104	Урамшуулал	8,616,600.00	11,540,692.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,438,032.86	20,881,100.00
210201	Тэтгэврийн даатгал	14,455,135.50	14,199,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,245,999.26	1,670,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	996,399.30	835,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	249,099.50	835,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,491,399.30	3,341,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,563,825.96	6,890,490.26
210301	Гэрэл, цахилгаан	1,040,000.00	1,610,000.00
210302	Түлш, халаалт	2,658,535.28	3,613,428.76
210303	Цэвэр, бохир ус	865,290.68	1,667,061.50
2104	Хангамж, бараа материалын зардал	11,573,818.47	9,367,697.92
210401	Бичиг хэрэг	5,190,875.00	2,740,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,997,821.00	4,582,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,385,122.47	2,045,177.92
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,194,000.00	2,727,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	932,000.00	2,727,400.00
210604	Урсгал засвар	11,262,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,920,375.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	1,920,375.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	472,518,184.00	479,261,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	470,063,664.00	470,941,940.00

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	347,600.00	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	3,270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,597,750.00	12,572,120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,977,750.00	6,139,620.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,620,000.00	6,432,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,370,760,586.23	10,873,203,622.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,854,131.00	972,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,854,131.00	972,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,333,906,455.23	10,872,231,622.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,333,906,455.23	10,872,231,622.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,087,600.00	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,087,600.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,087,600.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	31,087,600.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	31,087,600.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(31,087,600.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,130,936.43	21,130,936.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,130,936.43	21,130,936.43
Тайлант үеийн үр дүн	221,516,978.78	221,516,978.78
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,647,915.21	242,647,915.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,270,000.00)	(3,270,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	239,377,915.21	239,377,915.21
Тайлант үеийн үр дүн	(200,991,485.90)	(200,991,485.90)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,386,429.31	38,386,429.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	708,091,100.00	695,576,159.22	12,514,940.78	98.2
УРСГАЛ ЗАРДАЛ	708,091,100.00	695,576,159.22	12,514,940.78	98.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,110,100.00	694,604,159.22	12,505,940.78	98.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	167,045,100.00	164,253,036.04	2,792,063.96	98.3
Үндсэн цалин	101,473,700.00	100,258,075.55	1,215,624.45	98.8
Нэмэгдэл	28,035,200.00	29,474,267.61	(1,439,067.61)	105.1
Унаа хоолны хөнгөлөлт	23,340,000.00	22,980,000.00	360,000.00	98.5
Урамшуулал	14,196,200.00	11,540,692.88	2,655,507.12	81.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,881,100.00	20,881,100.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	14,199,000.00	14,199,000.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	1,670,500.00	1,670,500.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	835,300.00	835,300.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	835,300.00	835,300.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	3,341,000.00	3,341,000.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,212,800.00	6,890,490.26	2,322,309.74	74.8
Гэрэл, цахилгаан	2,940,000.00	1,610,000.00	1,330,000.00	54.8
Түлш, халаалт	3,868,000.00	3,613,428.76	254,571.24	93.4
Цэвэр, бохир ус	2,404,800.00	1,667,061.50	737,738.50	69.3
Хангамж, бараа материалын зардал	10,500,000.00	9,367,697.92	1,132,302.08	89.2
Бичиг хэрэг	2,740,000.00	2,740,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	5,000,000.00	4,582,520.00	417,480.00	91.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,760,000.00	2,045,177.92	714,822.08	74.1
Эд хогшил, урсгал засварын зардал	2,727,400.00	2,727,400.00	-	100.0
Багаж, техник, хэрэгсэл	2,727,400.00	2,727,400.00	-	100.0

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Томилолт, зочны зардал	2,000,000.00	1,920,375.00	79,625.00	96.0
Дотоод албан томилолт	2,000,000.00	1,920,375.00	79,625.00	96.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	482,169,600.00	475,991,940.00	6,177,660.00	98.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	476,645,600.00	470,941,940.00	5,703,660.00	98.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	250,000.00	50,000.00	200,000.00	20.0
Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	-	-	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	124,000.00	-	-	-
Бараа үйлчилгээний бусад зардал	12,574,100.00	12,572,120.00	1,980.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	6,141,600.00	6,139,620.00	1,980.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,842,600.00	6,432,500.00	3,410,100.00	65.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	981,000.00	972,000.00	9,000.00	99.1
Бусад урсгал шилжүүлэг	981,000.00	972,000.00	9,000.00	99.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	981,000.00	972,000.00	9,000.00	99.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	708,091,100.00	4,728,098,090.58	(4,020,006,990.58)	667.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	688,091,100.00	632,591,100.00	55,500,000.00	91.9
Улсын төсвөөс санхүүжих	688,091,100.00	632,591,100.00	55,500,000.00	91.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	4,095,506,990.58	(4,075,506,990.58)	20,477.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	184,217,810.50	(164,217,810.50)	921.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,911,289,180.08	(3,911,289,180.08)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	71411	71411	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	6,842,979,691.05
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	6,842,979,691.05
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,842,979,691.05
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	6,842,979,691.05
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,842,979,691.05
131101	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,189,593,168.05
131105	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,653,386,523.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 17,519.3 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн гүйлгээний тайлан 3,270.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан, тайлангийн тодруулгууд ирүүлээгүй.	1	3,270.0	-	-	1	3,270.0	1	3,270.0	-	-	-	-
2	Үндсэн хөрөнгийн элэгдэл татагдаагүйгээс үр дүн буруу тайлагнагдсан	1	14,249.3	1	14,249.3	-	-	1	14,249.3	-	-	-	-
	Дүн	2	17,519.3	1	14,249.3	1	3,270.0	2	17,519.3	-	-	-	-

3.2 Аудитаар нийт 109,851.2 мянган төгрөгийн 6 зөрчил илэрснээс 80,834.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 29,017.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Байгаль орчин, уур амьсгалын сангийн эрх зүйн орчныг судлах, холбогдох хуулийн төсөл боловсруулах гэрээт ажилд 20,000.0 мянган төгрөг, Байгаль орчны бодлого шийдвэрийг олон нийтэд сурталчлах ажилд хамтран ажиллахад үүсэх харилцааг зохицуулах, талуудын эрх, үүргийг тодорхойлох гэрээт ажилд 20,000.0 мянган төгрөг, нийт 40,000.0 мянган төгрөгийн гэрээт ажлыг 2024.12.24-2025.01.24-ний өдрийн дотор гүйцэтгүүлэхээр, урьдчилгаа төлбөрт 70 хувь олгож, ажлын тайлан, гэрээ дүгнэсэн актад үндэслэн 30 хувийг олгохоор гэрээнд тусгасан байх боловч санхүүжилтийг бүрэн олгож, зардлаар тайлагнасан байна.	1	40,000.0	-	-	1	40,000.0	-	-	-	-	-	-
2	Агаарын бохирдлын чиглэлээр олон нийтэд мэдээлэл хүргэх, соён гэгээрүүлэх, Уур амьсгалын өөрчлөлт хүний эрхийн чиглэлийн сургалт зохион байгуулах зэрэг нийт 40,834.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил үйлчилгээг 2024.12.20-2024.12.27-ны өдрүүдэд 2-3 хоногт гүйцэтгэхээр 3 аж ахуйн нэгжтэй гэрээ хийж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж санхүүжилтийг бүрэн олгосон байна. Ийнхүү жилийн эцэст богино хугацаанд ажил	1	40,834.0	-	-	1	40,834.0	-	-	-	-	-	-

Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	гүйцэтгүүлэх нь ажлын чанар муудаж, хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байх эрсдэлтэй байна.												
3	Санд төвлөрүүлэхээр тогтоосон, ногдуулсан хураамж, ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс, нөхөн төлбөрийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам зэрэг холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас мэдээлэл, судалгаа авч тооцоо хийгээгүй, авлага үүсгээгүй, хяналт хангалтгүй байна. Мөн Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар "Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээллийн сан" үүсгэсэн боловч, мэдээллийн сангийн ашиглалт хангалтгүй, мэдээлэл оруулаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22 нэр төрлийн 28,932.2 мянган төгрөгийн хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	28,932.3	-	-	-	-	1	28,932.3	-	-	-	-
5	Цалин хөдөлмөрийн хөлснөөс суутгасан ХХОАТ-ыг төлөөгүй, өр үүссэн байна.	1	84.9	-	-	-	-	1	84.9	-	-	-	-
6	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан 15 нэрийн байгалийн баялаг, эд зүйлс тус сангийн НББ-ийн хураангуй дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэгдээгүй, үнэ нь тодорхойгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	6	109,851.2	-	-	3	80,834.0	3	29,017.2	-	-	-	-

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт 237,161.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 207,343.7 мянган төгрөгийн 22 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	207,343.7	-	-	1	207,343.7	-	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгаль орчны 2021-2023 оны төлөв байдлын тайланг нэгтгэн боловсруулж, инфо эхийг бэлтгэх зөвлөх үйлчилгээний гэрээт ажил 10,000.0 мянган төгрөг, Байгаль орчны 2021-2023 оны төлөв байдлын тайлан номын эхийг бэлтгэж, эх тайланг 100ш, инфо тайланг 150 ш хэвлэх гэрээт ажил 19,818.0 мянган төгрөг, нийт 29,818.0 мянган төгрөгийн худалдан авалтыг нэг эх үүсвэрээс шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна	1	29,818.0	-	-	1	29,818.0	-	-
Дүн	2	237,161.7	-	-	2	237,161.7	-	-